

**“ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ”
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын энэхүү тогтоолын төслийн гол зорилго нь Улаанбаатар хотын газар олголттой холбоотой 1992 оноос өнөөг хүртэлх бүх шийдвэр, үйл ажиллагааг иж бүрэн шалгаж, нийтийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн зөрчил, алдаа дутагдлыг илрүүлж, цаашдын бодлого, хууль эрх зүйн шинэчлэлд шаардлагатай санал дүгнэлтийг боловсруулахад оршино. Тогтоолыг Монгол Улсын Үндсэн хуулийн хорин наймдугаар зүйлийн хоёр дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн хорин наймдугаар зүйлийн хорин наймдугаар хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн зургаа дугаар зүйлийн 6.1.7 дахь заалт болон гучин хоёрдугаар зүйлийн 32.1, 32.2, 32.3, мөн гучин гуравдугаар зүйлийн 33.1, 33.2, 33.8 дахь хэсгийг үндэслэн боловсруулсан бөгөөд эдгээр нь Улсын Их Хуралд хяналт шалгалт хийх, түр хороо байгуулах, шалгалтын үр дүнд дүгнэлт, санал гаргах бүрэн эрхийг олгож байна.

Тусгай шалгалтын гол зорилт нь Улаанбаатар хотын газар олголтын шийдвэрүүдийн хэрэгжилт, хууль зөрчсөн эсэх, нийтийн эрх ашигт хохирол учруулсан асуудлыг илрүүлэх бөгөөд үүний үр дүнд газар ашиглалт, өмчлөлийн ил тод, шударга тогтолцоог бий болгох бодитой санал дүгнэлт гаргах явдал юм. Шалгалтын хүрээнд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга болон холбогдох захиргааны байгууллагын 1992-2025 онд гаргасан газар олголттой холбоотой бүх шийдвэрийг судлан дүгнэхээс гадна Газрын тухай хуулийн хэрэгжилт, газрыг өмчлөл, эзэмшил, ашиглалтын зориулалтаар олгосон бодит байдал, нийтийн эзэмшлийн газар, ногоон байгууламж, гол усны хамгаалалтын бүс зэрэг хуульд хориглосон бүсэд газар олгосон эсэх, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эмнэлгийн эдэлбэр газарт газар олголт хийсэн байдал, газар олголтын ил тод байдал болон мэдээллийн сангийн үнэн зөв, одоогийн эрх зүйн орчин, хэрэгжилтийн зөрчил, цаашид өөрчлөлт оруулах шаардлага зэрэг чиглэлээр иж бүрэн хяналт шалгалт хийнэ.

Энэ ажлыг хэрэгжүүлэхийн тулд Улсын Их Хурлын хянан шалгах түр хороог байгуулж, олонхыг төлөөлсөн таван гишүүн, цөөнхийг төлөөлсөн дөрвөн гишүүнтэйгээр бүрдүүлэх бөгөөд гишүүдийн нэрсийг тогтоол батлагдах үед тодорхой тусгана. Түр хороо нь шалгалтыг иж бүрэн зохион байгуулж, нотолгоо баримт дээр тулгуурласан тайлан, санал, дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн гучин хоёрдугаар зүйлийн 32.7-д заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй.

Тогтоол нь 2025 оны есдүгээр сарын тодорхой өдрөөс эхлэн хэрэгжиж эхлэх бөгөөд ингэснээр нийслэл Улаанбаатар хотын газар олголттой холбоотой өнгөрсөн гуч гаруй жилийн бодит байдлыг бүхэлд нь нягталж, хууль зөрчсөн шийдвэр, нийтийн эрх ашгийг хохироосон үйлдлийг илрүүлэх, газар ашиглалт болон

өмчлөлийн ил тод, шударга тогтолцоог бий болгох бодлого, хууль эрх зүйн шинэчлэл хийхэд суурь мэдээлэл, чухал баримт нотолгоо болох юм.

Нэг дэх заалтаар Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдвийг “Улаанбаатар хотын газар олголтын шийдвэр, газар ашиглалтын байдал, гарсан алдаа, зөрчил, газар олголтын үр дагаварт бий болсон нийтийн эрх ашигт харшлах асуудлыг тодорхойлох зорилгоор холбогдох тогтоол, шийдвэр, газар олголтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх” гэж тусгасан.

Хоёр дахь заалтаар Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын хүрээ хязгаарыг дараах байдлаар тусгасан. Үүнд:

1/.Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг дарга болон холбогдох захиргааны байгууллагын гаргасан газар олголттой холбоотой 1992-оос 2025 оны шийдвэрүүд;

2/.Газрын тухай хуулийн хэрэгжилт, газрыг өмчлөл, эзэмшил, ашиглалтын зориулалтаар олгосон байдал;

3/.Нийтийн эзэмшлийн газар, ногоон байгууламж, гол усны хамгаалалтын бүс зэрэг хуульд хориглосон бүсэд газар олгосон эсэх;

4/.Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсрол, эмнэлгийн эдэлбэр газарт газар олголт хийгдсэн байдал;

5/.Газар олголтын ил тод байдал, мэдээллийн сангийн бодит байдал;

6/.Одоогийн эрх зүйн орчин, хэрэгжилтийн зөрчил, цаашид өөрчлөлт оруулах шаардлага зэргийг судлан хяналт шалгалт хийх, санал, дүгнэлт гаргах.

Гурав дахь заалтад Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнийг тусгасан.

Дөрөв дэх заалтаар Улсын Их Хурлын хянан шалгах түр хороонд гаргасан тайлан, санал, дүгнэлтээ Улсын Их Хуралд танилцуулахыг Улсын Их Хурлын хянан шалгах түр хороонд даалгахыг даалгасан.

ТӨСӨЛ САНААЧЛАГЧ